

МОНГОЛ ГЭРИЙН ТАВИЛГА БАЙРЛУУЛАХ ЁСЫГ МЭДЭХ

D.Urantsetseg@must.edu.mn

**ГЭРИЙН
ЭЗНИЙ ОР**

АВДАР



**ЭЗЭГТЭЙН
ОР**

АРСЛАНТАЙ АВДРЫН ТУХАЙ

Дөрвөн хүчтэний нэг арслангаар эд баялгаа хамгаалуулан авдар дээрээ зурж сийлдэг байжээ. Авдартаа үнэ цэнэтэй зүйлээ хадгалахаас гадна хурганы арьс, шагай, сур, арвай, арц ганга гэх мэт 9 зүйлийг дээжлэн хийдэг байсан. Арсланг хоёр тийш харуулдаг нь сахин хамгаалах билэгдэл болно. Арслангийн аманд эдийн дээд хэмээн билэгдэн хадаг зуулгах эсвэл саварт нь эрдэнэ билэгдэж молор атгуулсан, үр удмаа хамгаалж байхыг билэгдэж гүеэг тэврүүлсэн гэх мэт олон янзаар дүрсэлсэн байдаг.





ДАСГАЛ-3

Бие дааж гүйцэтгээрэй

ДУГНЭЛТ

Монгол гэрийн доторх орон зайг гал голомтоор төвлөх бөгөөд баруун, зүүн, хоймор, үүдэн тал хэмээн ерөнхий дөрөв хуваарилаад, дөрвөн зүг, найман зовхистын зүгийн бэлгэдэлд тохируулан тавилга, хэрэгслийг байрлуулж, гэрийн эздийн орон зайг тодорхойлдог.

Монгол гэр өрөө тасалгаагүй, эвлэлдэн нэгдэх нөхцөлийг хангасан, ахмад настнууд нь үр хүүхдээ, ажил амьдралд сурган, хөгжүүлж, өөрийн биеэр үлгэрлэн хүмүүжүүлдэг онцлогтой. Ажил амьдралын явцад хүүхэд ахмадаа хүндэтгэх, дүү, аав ээжээ ачлах ёсонд суралцдаг юм. Нэг ёсондоо айл өрх бүр сургууль ажээ.

Монголчууд хүүхдэдээ бага наснаас нь эрдэм ном, ажил хөдөлмөрийн чухлыг ойлгуулахын тулд гэрийн сургалтын тогтолцоог бүрдүүлж, сургаж ирсэн түүхтэй. Гэрийн сургалтаар аж ахуй, ардын эмнэлэг, оюун ухааныг хөгжүүлэх, мэдлэг боловсролтой болгох гэх мэт хүнийг хүн болгох арга ухаанд сургадаг ажээ.